


ЭРДЭНЭТ ХОТЫН ИРГЭД, СОНГОГЧИД ОО

Эрдэнэт хотын Монгол Ардын намаас 2020 оны орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд Эрдэнэт хотын эзэд Та бүхнийхээ сайн сайхан амьдрал, хотынхоо нийгэм – эдийн засаг, экологийн тогтвортой хөгжлийг хангах асуудлыг баттай бүрдүүлэх зорилгоор иргэдээс ирсэн санал хүсэлт, удаа дараагийн судалгааны дүн, 2016-2020 онд хэрэгжүүлсэн бодит ажил, хүрсэн үр дүнд үндэслэн боловсруулсан “ ХҮНИЙ ХӨГЖИЛ – ЭРДЭНЭГИЙН ХӨГЖИЛ” хөтөлбөрөө танилцуулж байна. Хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэхийг урьж байна.

Мөрийн хөтөлбөр нь найман үндсэн зорилттой. Үүнд:


1. Эрүүл мэнд, чийрэгжүүлэлтийн үйлчилгээ
2. Нийгмийн халамжийн үйлчилгээ
3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны хөгжил
4. Эрүүл хүнс, цэвэр орчин, ногоон хөгжил
5. Дэд бүтцийн хөгжил
6. Аялал жуулчлалын шинэ бодлого
7. Үйлдвэрлэл, эдийн засгийн хөгжил
8. Найдвартай засаглал


Иргэн Таны болон төрөлх Эрдэнэт хотын хүсэл тэмүүлэл, хөгжил дэвшлийн зангилаа асуудлыг шүүн тунгааж боловсруулсан хөтөлбөртэй тав тухтай танилцаж хамтран ажиллана гэдэгт итгэл төгс байна.




ЭРДЭНЭТ ХОТЫН МОНГОЛ АРДЫН НАМ

№	<p>Нам эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ</p>	<p>Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн тооцооллыг хийхдээ төсвийн төсөөллийг баримталсан эсэх (тийм, үгүй)</p>	<p>Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн аль заалтад хамаарч буй</p>	<p>УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” буй, мөн аймаг, нийслэлийг хөгжүүлэх зорилтын (холбогдох заалтыг бичих)</p>	Тайлбар
1	<p>1</p> <p>ЭРҮҮЛ МЭНД, ЧИЙРЭГЖҮҮЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:</p> <ul style="list-style-type: none"> - Эрдэнэт хотын бүсийн оношлогоо эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн менежмент, тоног төхөөрөмжийн хангамж, хүний нөөцийн чадавхыг сайжруулж улс, бүсийн тэргүүлэх эрүүл мэндийн байгууллагын хэмжээнд хүргэх хөтөлбөр хэрэгжүүлнэ - Эрдэнэт хотод ажиллаж байгаа “Медипас” эмнэлгийн оношлогоо, үйлчилгээг дэлхийн жишигт хүргэж эрдэнэт хотын иргэд гадаад дотоод явж үйлчлүүлдэг практикийг хязгаарлана. - Хотын нийт байгууллагад “Эрүүл хамт олон” хөтөлбөр хэрэгжүүлнэ. - Цэнгэлдэх хүрээлэнгийн орчны дахин төлөвлөлт хийж Эрдэнэтчүүдийн амралт чөлөөт цагийн тааламжтай бүс бий болгоно. - “Эрдэнэт” төрийн өмчийн үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалтаар “Бөхийн өргөө” цогцолбор барих асуудлыг бодлогоор дэмжиж ардын хувьсгалын 100 жилийн ойн өмнө ашиглалтад оруулна. - Олон улсын чанартай А зэрэглэлийн тэмцээнийг өвөл, зуны тодорхой төрлөөр зохион байгуулах боломжийг бүрдүүлж 2-оос 	<p>2</p> <p>Тийм</p>	<p>3</p>	<p>4</p> <p>“Алсын хараа”-2050 урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 2.2, 3.5</p>	5

2	<p>доошгүй олон улсын чанартай спортын арга хэмжээг зохион байгуулна.</p> <ul style="list-style-type: none"> - Хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөн өрнүүлэх иргэдийн санал санаачлагыг дэмжин хамрагдагсдын тоог 2 дахин нэмэгдүүлнэ. - Архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээний талаар эрүүл, амьдралын зөв дадал, хэвшлийг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ. - Нийгмийн болон орчны эрүүл мэндийн тандалт судалгаа хийж, түүний үр дүнд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлого боловсруулан хэрэгжүүлнэ. - Эрүүл мэндийн салбарт төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ. - Хүн амыг стандартын шаардлага хангасан чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгсэлээр хангана. - Эмч, эмнэлгийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлж тэдний тав тухтай ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. - “Эрдэнэт” шинжлэх ухаан технологийн паркийн дэргэдэх хүнд элементийн лабораторийн шинжилгээний чанар, стандартын жигд ажиллагааг хангаж үйлчлүүлэгдийн хүрээг өргөжүүлнэ. <p>НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:</p> <ul style="list-style-type: none"> - Залуу гэр бүл болон бага дунд орлоготой айл өрхийг орон сууцаар хангахад эрс өөрчлөлт гаргана. Энэ асуудлыг хот, “Эрдэнэт” төрийн өмчийн үйлдвэрийн хамтын ажиллагааны нэг чиглэл болгож ажиллана. 	Тийм		<p>“Алсын хараа”- 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 2.3, 3.1,</p> 
---	--	------	--	--


3	<p>- Ахмад настанаа дэмжих "Ач санах" дэд хөтөлбөр, Эрдэнэтийн анхдагч, илгээлтийн эздэд "Анхдагч" дэд хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлсэн шаардлагатай ажил, арга хэмжээг үргэлжлүүлэхийн хамт шинэ агуулгаар баяжуулж ажиллана.</p> <p>- Хөгжлийн бэрхшээлтэй болон өрхийн амьжиргааны түвшин доогуур өрхийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хотын комисс байгуулж шаардлагатай судалгаа, дүгнэлт боловсруулж бодит ажил хэрэг болгоно.</p> <p>- Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмад настан зэрэг зорилтод бүлэг рүү чиглэсэн нийгмийн халамж, хамгааллын бодлогыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах ажлыг цахим хэлбэрээр нийтэд нээлттэй зохион байгуулна.</p> <p>- Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрхийн амжиргааны баталгаажих төвшингөөс доогуур орлоготой иргэдэд чиглэсэн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.</p> <p>- Ахмадын хөгжлийн төвүүдийн үйлчилгээний стандарт бий болгож тэдгээрийн үйл ажиллагааг дэмжих төсөл хэрэгжүүлнэ</p> <p>БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ХӨГЖИЛ:</p> <p>- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 100 хувь бүтээмж дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, боловсролын үйлчилгээний чанар, менежментийг сайжруулна..</p> <p>- Ардын уламжлалт зан үйл, ёс зүй, зан заншил, зөв амьдрах ухаан, хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхэнд монголчуудын оруулсан хувь нэмэр, байгальтайгаа хүйн холбоотой амьдарч ирсэн</p>	Тийм		<p>"Алсын хараа"- 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 1.4, 2.1, 2.4</p> 
---	--	------	--	--


	<p>Монголчуудын өв уламжлал, харилцааны ёс зүй, суурь үнэт зүйлсийг цэцэрлэг, ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт оруулж хэрэгжүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Сургууль, цэцэрлэгийг шаардлагатай багуудад шинээр барина, засварлана, өргөтгөнө. - Ерөнхий боловсролын бүх сургуулиуд чанарын удирдлагын систем нэвтрүүлнэ. - Техник- технологийн сургалттай ерөнхий боловсролын сургууль байгуулах санал санаачлагыг дэмжиж хамтран ажиллана. - Боловсролын хөгжлийн асуудлаар бүс , үндэсний түвшний арга хэмжээ зохион байгуулж уламжлал болгох - Их дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн байгуулж, “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийг түшиглэн уул уурхайн сургалтыг өргөжүүлж, шинжлэх ухаан технологийн паркыг өргөтгөн хөгжүүлнэ. - Төрийн болон хувийн хэвшлийн Их, дээд сургуулиудыг Сургалт-Үйлдвэрлэл- Эрдэм шинжилгээний цогцолбор төв болгож, хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрөөр өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэнэ. - Орхон МСҮТ-ийг Хангайн бүсийн мэргэжилтэй ажилтанг бэлтгэх, давшан сургах, мэргэшүүлэх цогцолбор коллеж болгож өргөтгөнө . - Ардын уламжлалт гар урлал, амьдрах ухааны чиглэлээр шавь сургалтыг дэмжинэ. - 2016-2020 онд хэрэгжүүлсэн “Багш” дэд хөтөлбөрт заасан чухал шаардлагатай арга хэмжээг 2020-2024 онд шинэ агуулгаар үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
--	---




 61171 4733
 СААБИС 011236


	<ul style="list-style-type: none"> - Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркыг түшиглэн боловсрол эрдэм, шинжилгээ, үйлдвэрлэлийн уялдаа холбоог бий болгон, сургалтын чанарыг дээшлүүлэх, оюутан суралцагчдын бүтээлч байдлыг хөгжүүлнэ. - Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор иргэдэд ахуйн болон нийтийн үйлчилгээ, худалдаа нийтийн хоол, хөнгөн ба хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэжил боловсрол олгох түр сургалтуудыг дэмжинэ. - Стандартын шаардлага хангасан киноны хүрээлэн, мэргэжлийн театр, чуулга байгуулна. - Биеийн тамирын байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлж, менежментийг сайжруулж, нийтийн биеийн тамирыг эрчимтэй хөгжүүлнэ. - Стандартын шаардлага хангасан музейн барилга барьж, үзмэрийн сан хөмрөгийг нэмэгдүүлж, хадгалалтыг сайжруулна. - Хувийн хэвшлийн соёл, урлагийн байгууллагуудыг дэмжиж хамтран ажиллана. - "Гэр бүл- үндэсний соёл, зан заншил" хөтөлбөр хэрэгжүүлнэ - Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнд "Монгол наадгай" өргөө байгуулж хүүхэд залуучуудад монголчуудын соёлын уламжлал, үнэт зүйлсийг өвлүүлэн хөгжүүлэх бичил төв болгоно. - Хүүхэд, залуучуудын хөгжлийн цогцолбор төв, олон улсын чанар, стандартад нийцсэн жишиг ерөнхий боловсролын сургууль, номын сан барина. 			
--	--	--	--	--




<p>4</p>	<p>- Эрдэнэт хотын хүн ам, нийгэм- эдийн засгийн хөгжлийн асуудлаар шинжлэх ухааны академи, төрөлжсөн хүрээлэнгүүдтэй хамтран жил бүр 1-ээс доошгүй төсөл хэрэгжүүлнэ.</p> <p>ЭРҮҮЛ ХҮНС, ЦЭВЭР ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ:</p> <p>- Иргэдийн сүү, сүүн ба гурил, гурилан бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгаас хангана.</p> <p>- Зоорьтой зах байгуулж, иргэдийн төмс, хүнсний ногооны хэрэгцээг 100 хувь хангана.</p> <p>- Хүн амын хэрэглээний усыг ангилан саарал усыг ашиглах, ундны усыг цэнгэгжүүлэх, зөөлрүүлэх технологийг судалж хэрэгжүүлэх төслүүд хэрэгжүүлнэ.</p> <p>- Гадаргын усны ашиглалтыг сайжруулж, усны эх булаг, шандыг хамгаалан тохижуулж, усны нөөцийн хамгаалалт, хэмнэлттэй технологийг нэвтрүүлж, гүний худаг байгуулах ашиглахыг хязгаарлан, бохирдолтыг бууруулах ажлыг эрчимжүүлнэ.</p> <p>- Эрдэнэт хотын болон хил залгаа аймгуудын нутаг дэвсгэрт өрхийн тариалалтыг дэмжих, хамтарч ажиллах төсөл боловсруулж хэрэгжүүлнэ.</p> <p>- Уламжлалт нүүдлийн болон эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх ажлыг өргөжүүлж хоршоо, фермерүүдийг дэмжинэ.</p> <p>- Баталгаатай, стандартад тохирсон хүнс, ногоо, мах махан бүтээгдэхүүнээр найдвартай хангадаг үйлчилгээний цэг, салбар төвүүдийг бодлогоор дэмжиж, эрүүл ахуйд нийцсэн орчин бүхий Эрдэнэт хотыг бий болгоно.</p> <p>- Үүлдэр омог гойд ашиг шимт малыг өсгөн үржүүлнэ.</p>	<p>Тийм</p>	<p>“Алсын хараа” - 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 2.5, 6.1</p>	
----------	---	-------------	---	---

- Мал амьтны ус хангамжийн хүрэлцээг нэмэгдүүлж, өвөлжөө хаваржааны бэлчээрийг худаг уст цэгийн хамт малчдын бүлгүүдэд оновчтой хэлбэрээр эзэмшүүлнэ.
- Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний стандарт, хүртээмж, материаллаг бааз, боловсон хүчний хангамжийг сайжруулна.
- Өндөр ургац өгдөг сортын үр тариа, тэжээлийн ургамлын болон жимс жимсгэний тариалалтыг нэмэгдүүлнэ.
- Хүлэмжийн аж ахуй байгуулах, нарийн ногоо тарих хөдөлгөөн өрнүүлж, өвлийн хүлэмж байгуулах иргэд, аж ахуй нэгж, байгууллагын санал санаачлагыг дэмжин хамтран ажиллана.
- Хөрсний бохирдолыг бууруулах цогц бодлогыг хэрэгжүүлж, байгаль орчинд ээлтэй цэвэр үйлдвэрлэл, хэмнэлттэй хэрэглээг дэмжиж урамшуулах эдийн засгийн хөшүүргийг бий болгон төр, хувийн хэвшлийн бүх байгууллагад ногоон хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлнэ.
- Ногоон хөгжил хандлага, үзэл санаа, дадлыг олон талын оролцоонд тулгуурлан хөгжүүлнэ.
- Эрдэнэт хотын ойр орчмын зуслангийн бүсэд айл өрхийн ногоон стандарт бий болгож хөгжүүлнэ.
- Ногоон айл өрх, байгууллага, гудамж, хороолол, багийн стандарт боловсруулж нийтийн хөдөлгөөн өрнүүлж ногоон хот бий болгоно.
- Гэр хороололд МОН-23-01 төслөөр татагдсан 40 км цэвэр усны шугамыг ашиглахад шаардлагатай бохирын шугам татаж, эко жорлон тэслийг эрчимжүүлнэ.
- “Утаагүй Эрдэнэт” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.




5	<p>- Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах иргэд аж ахуйн нэгжийн санал санаачлагыг бодлогоор дэмжинэ.</p> <p>- Голын гольдрол, гуу жалга, далангийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үерийн далангийн байгууламжийг нэмэгдүүлэн гадаргын усны бохирдлыг бууруулна.</p> <p>- Баян-Өндөр, Сархиа уулыг ойжуулах, тохижуулах арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.</p> <p>- Ойн нөөцийг хамгаалах нөхөн сэргээх, ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалахад ой модны зохистой ашиглалт, тогтвортой менежментийг бий болгож, ойн санг нэмэгдүүлэн, модны хэрэглээг бууруулна.</p> <p>- Эрдэнэт үйлдвэрийн цагаан тоосыг дарах шинэ технологийг бий болгон, хотын хүн амын эрүүл мэндийг хамгаална.</p>			
	<p>ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ:</p> <p>- Олон төрлийн /орлогод нийцсэн, түрээсийн, ногоон/ орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, инженерийн хангамжтай 5000 орон сууцаар хангана. Үүнд:</p> <p>a. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөж, барилгажуулах төсөл-1500</p> <p>b. Шинэ суурьшлын бүс хөгжүүлэх төсөл-1500</p> <p>c. Зөвшөөрөл олгогдсон барилгажилт төсөл- 1000</p> <p>d. Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгуудыг буулгаж, шинээр барих төсөл- 500</p> <p>e. Түрээсийн орон сууц- 500</p> <p>- Шинээр хашаа байшин, сууц барьж буй иргэдийг ипотекийн зээлд хамруулна.</p>	Тийм	<p>“Алсын хараа”- 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 2.5, 3.2, 3.6,</p>	


	<ul style="list-style-type: none"> - Эрдэнэт Булганы хооронд шинэ суурьшлын бүс байгуулах эрх зүйн баримт бичиг боловсруулан хэрэгжүүлнэ - Хялганат-Хангал-Эрдэнэт чиглэлийн 53 км хатуу хучилттай авто зам, Төв аймгийн Жаргалант-Эрдэнэт чиглэлийн авто зам барьж, хотын доторх авто замыг өргөтгөж, шинэчилнэ. - Хотын цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийг ашиглалтанд оруулж менежментийг нь сайжруулна. - Хотын инженерийн шугам сүлжээг тодорхой үе шаттай шинэчлэн сайжруулна. - Эрдэнэт хотод гудамж, талбайн нэр, байшин барилгын хаягийн нэгдсэн стандарт хэрэгжүүлнэ. - Дулааны цахилгаан станцын шинэчлэл төсөл хэрэгжүүлж, алслагдсан гэр хорооллуудыг дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнд холбоно. - Гэр хорооллын бүх багт “Миний гудамж-Бидний гэр” төслийг хэрэгжүүлж зам талбай, гэрэлтүүлэг, камержуулалтыг дэс дараатайгаар үргэлжлүүлэн шийдвэрлэнэ. - Нарны эрчим хүчийг дулааны эх үүсвэр болгон ашиглах технологи нэвтрүүлнэ. - Эрдэнэт хотод шөнийн эрчим хүчийг тэглэх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлэнэ. - Орон сууцны хорооллуудын дунд авто машины далд зогсоол барих иргэд аж ахуй нэгж, байгууллагуудын санал санаачлагыг урьдын адил дэмжиж хамтран ажиллана. 			
--	---	--	--	--




	<p>- Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл маршрутыг иргэдийн саналд тулгуурлан оновчтой болгож, нийтийн тээврийн үйлчилгээний стандарт боловсруулж хэрэгжүүлнэ.</p> <p>- Хот тохижилт, хог хаягдлын асуудлыг орчин үеийн хотын хөгжилд нийцүүлэн шийдвэрлэж, иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.</p> <p>- Шинээр барих орон сууцны байр, хороолол, томоохон объект барих ажлыг инженерийн болон нийгмийн дэд бүтцийг хамтад нь төлөвлөж батлуулсаны дараа эхэлдэг практикт шилжинэ.</p>			
6	<p>АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ШИНЭ БОДЛОГО:</p> <p>- Эрдэнэт хотын доторх аялал жуулчлалын нэгдсэн сүлжээг бий болгож үйл ажиллагааг нь жигдрүүлж гадаад дотоодын аялагчид, жуулчдад үйлчилнэ.</p> <p>- Баян-Өндөр сумын Цагаанчулуут багт баригдсан цэцэрлэгт хүрээлэнгийн техник тоног төхөөрөмж, материаллаг бааз, менежментийг сайжруулж хүүхэд залуучууд, гадаад дотоодын аялагчдын амралтын мини бүс болгоно.</p> <p>- Баян-Өндөр уулыг иргэдийн идэвхитэй амралтын бүс, аялал жуулчлалын цогцолбор болгон хөгжүүлнэ.</p> <p>- Жуулчны бааз, мэдээллийн төв байгуулах санал санаачлагыг бодлогоор дэмжиж, зочид буудлуудыг олон улсын зэрэглэлтэй болгох ажлыг зохион байгуулан дотоод, гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлнэ.</p> <p>- Өвлийн спортын материаллаг баазыг бэхжүүлж дотоодын өвлийн аялал жуулчлалыг нэмэгдүүлнэ.</p>	Тийм	<p>“Алсын хараа” - 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 1.2, 6.2</p>	
7	<p>ҮЙЛДВЭРЛЭЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ:</p> <p>- Аж үйлдвэрийн үйлдвэрлэл - технологийн паркийг байгуулна</p>	Тийм	<p>“Алсын хараа” - 2050 урт хугацааны</p>	

<p>- Хотын нөөцийн давуу талд тулгуурлан уул уурхай-металлурги-хими, катодын зэс боловсруулах үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.</p> <p>- “Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ”-г түшиглэн Орон нутгийн өмчит катодын зэсийн үйлдвэр, шахмал түлшний үйлдвэр барина.</p> <p>- Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, ажлын байрны тоог нэмэгдүүлэн өрхийн бодит орлогыг өсгөнө.</p> <p>- “Эрдэнэт” шинжлэх ухаан технологийн паркийн дэргэдэх бизнес инкубацийн үр ашгийг сайжруулж, бойжигчдын тоог нэмэгдүүлж жижиг дунд бизнес эрхлэгчдийн хүрээг өргөжүүлнэ .</p> <p>- “Эрдэнэт” шинжлэх ухаан технологийн паркийн гагнуурын электрод, будгийн үйлдвэрлэлийн чанар стандартыг бүрэн тогтворжуулж шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ</p> <p>- “Эрдэнэт” шинжлэх ухаан технологийн паркад барилгын хар замаск үйлдвэрлэж бүс, орон нутгийн зах зээлд нийлүүлнэ.</p> <p>- Өндөр технологид тулгуурласан экспортын баримжаатай, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх боломжийн судалгааг өргөжүүлж инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ</p> <p>- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах ажилд орон нутгийн аж ахуй нэгж байгууллагуудыг бодлогоор дэмжиж хамтран ажиллана.</p> <p>- Нөөцийн махыг орон нутгийн иргэд, аж ахуй нэгж, байгууллагад түшиглэж бэлтгэнэ.</p>		<p>хөгжлийн бодлогын зорилт 3.3, 3.4, 4.1, 4.2</p>
--	--	--



8	<p>- “Эрдэнэт” ТӨҮГ-зар болон бусад томоохон үйлдвэрүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлж хорших, туслан гүйцэтгэх үйл ажиллагааг өргөжүүлнэ.</p> <p>- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг сайжруулж иргэдэд нээлттэй болгоно.</p> <p>- Жаргалант сумыг түшиглэн Эрдэнэт хотыг Эко хүнсний бүтээгдэхүүнээр хангах, иргэд, аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжинэ.</p> <p>- Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх шинэ механизмыг /батлан даалт, хөнгөлттэй зээл, дэмжлэг гэх зэрэг/ урьдын адил бодлогоор дэмжиж хүртээмжийг нэмэгдүүлнэ.</p> <p>- Хил залгаа бүс нутаг, орон нутгийн түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлох үйлдвэрлэлд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд технологийг нэвтрүүлж, дотоодын хэрэгцээг бүрэн хангах бодлого барина.</p> <p>- Барилга, барилгын материалын чиглэлийн шинэ үйлдвэр, үйлчилгээг дэмжихийн хамт Хангайн бүсийн барилгын хөгжлийн судалгааны төвийг байгуулж иргэд, аж ахуй нэгжийн санал санаачлагыг дэмжиж байгуулж ажиллана.</p>	Тийм	“Алсын хараа” - 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 5.1 – 5.6	
	<p>НАЙДВАРТАЙ ЗАСАГЛАЛ:</p> <p>- “Эрдэнэт -2030” хөтөлбөр боловсруулж хөгжлийн 10 жилийн цогц бодлого хэрэгжүүлнэ.</p> <p>- Төрийн албаны томилгоонд улс төрийн албан хаагчийн нөлөөллийг хязгаарлана.</p>			

- Орон нутгийн / хотын / ИТХ-ын төлөөлөгчдийн үйл ажиллагаа, ёс зүйд хяналт тавьж хууль зөрчсөн, алдаа гаргасан тохиолдолд хариуцлага хүлээдэг хандлагыг төлөвшүүлнэ.
- Иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж, бодлого, шийдвэр, үүрэг даалгаварын биелэлтийг цахимаар хянадаг болно.
- “Цахим төрийн үйлчилгээ” хөтөлбөр хэрэгжүүлж төрийн үйлчилгээний шуурхай байдал, хүртээмжийг сайжруулна.
- Төрийн албан хаагчдын хувийн болон хамтын манлайллыг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.
- Орон нутгийн хурал, захиргааны байгууллагын бодлого, үйл ажиллагааны төлөвлөлт, шийдвэрийн хэрэгжилтэд иргэдийн оролцоог хангах механизм бий болгож энэ асуудлын хүрээнд сайн туршлага төрүүлнэ.
- Бизнесийн болон иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх ажлын хамрах хүрээг 2 дахин нэмэгдүүлнэ.
- “Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийн хамт багуудын өөр хоорондоо хамтарч ажиллах, ялгарч хөгжих санал санаачлыг өрнүүлнэ.
- Төрийн бүх шатны байгууллагуудын дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг сайжруулахын хамт төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэд хэрхэн үнэлж байгааг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн бармт бичгийн дагуу судалж ил тод мэдээлж, холбогдох арга хэмжээг авч ажиллана.
- Хөрш орнуудын муж, хотуудтай тогтоосон түншлэл, хамтын ажиллагаагаа шинэ агуулгаар баяжуулан хөгжүүлж, хөгжлийн олон



	<p>тулгуурт бодлого хэрэгжүүлэх шаардлагын үүднээс олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах чиглэлээр идэвхтэй ажиллана.</p> <ul style="list-style-type: none"> - Хил залгаа Булган, Сэлэнгэ аймаг, тэдгээрийн сумдтай хамтын ажиллагааг өргөжүүлж, тулгамдаж буй асуудлуудыг хамтран шийдвэрлэнэ. - Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж, төрийн албаны үйл ажиллагаанд үндэсний хэмжээнд шинээр хэрэгжүүлж байгаа гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг дүгнэх системийг үлгэр жишээ хэрэгжүүлнэ. - Дундын өмчлөлийн орон сууцны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, иргэд оршин суугчдын ая тухтай байдлыг бүрдүүлнэ. - Хотын иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг хангах үндсэн үүрэг бүхий төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, техник тоног төхөөрөмжийн хангамж, үйл ажиллагааны чанарыг сайжруулж гэмт хэргийн гаралтыг төрөл бүр дээр нь бууруулна. 				
--	--	--	--	--	--

Мэдээллийг бэлтгэсэн: Орхон аймгийн Монгол Ардын Нам-ыг төлөөлж

Дэд дарга

Баянмөнхийн Цолмон

Дэд дарга

Пүрэвжавын Пүрэвхатва



2020 оны 06 сарын 23 өдөр